



**Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн барих
Төрийн хүндэтгэлийн зоог дээр
Холбооны Ерөнхийлөгч Иоахим Гаукийн
хэлэх үг
2015 оны 10 дугаар сарын 15
Улаанбаатар хот, Монгол улс**

Хараа тэлсэн өргөн уудам нутгийг нь дурсалгүйгээр Монголын тухай ярих хүн Төв Европод бараг байхгүй биз ээ.

„Төв Азид очсон хүн дадсан хэмжүүрээ орхих ёстой болно. Бурхан дэлхийг хэрхэн бүтээсэн тэр өдөр нь тэнд хөл тавих хэрэгтэй” гэж хагас зуу гаруй жилийн тэртээ Азид аялсан Германы жуулчин Фритц Мюленвег бичжээ. Үүнд өнөөгийн Монголын нутаг ч хамаарах нь лавтай.

Монголын нутаг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсынхаас дөрөв дахин том. Гэтэл асар уудам энэ оронд гуравхан сая хүн оршин суудгийн тэн хагас нь нийслэл хотдоо аж төрж байна. Хүн ам ийм сийрэг суурьшсан нь олон герман хүний сэтгэлийг гойд татдаг. Хүн ам шигүү суурьшсан эх орныхоос нь тэс ондоо дүр зураг харагдаж байгаа хэрэг. Тэр ч бүү хэл энэ гурван сая хүний гучин мянга нь германаар ярьдаг, герман хэлний курсүүдэд суралцах дуртай байдаг гэж германчууд бид сонсохоороо энэ оронд бүр ч сэтгэл татагдана. Хэлээр нь ярьдаг л бол улс орныг нь ч бас сонирхож байдгийг бид мэдэх билээ. Өөрөөр хэлбэл гадаад хэл эзэмшинэ гэдэг хоёр улсын харилцааны чанарыг гойд сайн илэрхийлэх үзүүлэлт юм.

БНАГУ, Бүгд Найрамдах Монгол Ард Улс социалист ахан дүүсийн барилдлага гэгдсэн холбоогоор холбогдон байсан тухайн цаг үеэс Монгол-Германы харилцаа эхтэй. Гэхдээ бүр 1974 онд Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай мөн дипломат харилцаа тогтоосон. Ийнхүү манай өнөөгийн найрамдал нөхөрлөлийн бат бэх үндэс суурь тавигдсан юм.

Герман улс олон жилийн тэртээгээс Монголын соёлыг үлэмж сонирхож ирлээ. Чингис хааны эртний нийслэлд хийж буй малтлага зэрэг амжилттай хэрэгжиж байгаа археологийн хамтарсан

төслүүдийн ажлыг цааш нь үргэлжлүүлэх болно. Маргааш Хархорумд очиж үзэх гэж байгаадаа туйлын баяртай байна.

Гёте институт тэртээ 2008 оноос Улаанбаатарт төлөөлөлтэй болсон. Хамтарсан санхүүжилттэй Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр 2010 оноос монгол оюутнуудад Германы их дээд сургуулиудад суралцах боломжийг олгож байна. Ингээд 2013 онд Герман-Монголын Технологийн их сургууль Налайхад байгуулагдсан билээ. Тэнд хичнээн олон монгол залуус Германы дэмжлэгтэйгээр урам зориг дүүрэн сурч боловсорч байгааг миний бие өнөөдөр үдээс хойш очиж үзлээ. Манай хоёр орны Засгийн газрын 2011 онд байгуулсан ашигт малтмалын салбарын түншлэлийн хөтөлгүүр нь нэгэн цагт энэ сургууль болж болох юм. Намайг өнөөдөр дагалдан яваа эдийн засгийн салбарын төлөөлөгчдөөс бидний сонирхол хэвээр байгааг Та бүхэн олж харж буй биз ээ.

Ноён Ерөнхийлөгч өө,

Ноёд, хатагтай нар аа,

Коммунист дэглэмүүд өөрсдийн ноёрхож байсан нийгэмд үргэлжид ул мөрөө үлдээж байсан нь манай орнуудын хувьд ч бас бие биетэйгээ хуваалцах туршлага юм. Монголчууд 25 жилийн тэртээ тайван замаар хувьсгал хийж, зүүн германчуудын нэгэн адил ардчилал, зах зээлийн эдийн засгийг сонгож авсан, үүгээрээ том хөршүүдээсээ ялгаатай. Хүндэт ноён Ерөнхийлөгч Та саяхан өөрийн орны газарзүй, улс төрийн онцгой байрлалыг "Хоёр зааны дунд зогсч байгаа пони морь" -той зүйрлэж хэлсэн байна билээ.

Ноён Ерөнхийлөгч өө,

Та ардчилал, эрх зүйт төрт ёсыг бэхжүүлэх, үүний сацуу мөн авлигатай тэмцэхэд онцгой хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн билээ. Өнөөг хүртэл хүчин чармайлт тавьсаар байна, хамгийн сүүлд Нью Йоркод Нэгдсэн Үндэстний Байгууллагын өмнө хэлсэн үгэндээ ч үүнийгээ илэрхийлсэн. Энэ идэвх чармайлтаа сулруулах юм бол өдгөөг хүртэл хүрч гүйцэлдүүлсэн бүхэн баталгаагүй болж болно гэдгийг бид мэднэ, тийм болохоор энэ хүчин чармайлт гүнээ анхаарал, хүндэтгэл хүлээж байна. Хэдийгээр орчин нь хүнд төвөгтэй байгаа ч энэ замаараа замнахад нь Герман улс Монгол улсад дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байна. Бид түншлэлийн хүрээнд хийж чадахаа хийж Монголын нийгмийг цаашид ч хөгжин дэвжихэд нь хувь нэмрээ оруулах хүсэлтэй байна.

Энд дуртайяа ирэх болсон хувийн шалтгаан надад байгаа юм: 2012 оны 3-р сард Ерөнхийлөгчийн албыг шинээр аваад Берлинд хүлээн авсан төрийн анхны зочин маань ноён Ерөнхийлөгч Элбэгдорж байлаа.

Ингээд надтай хамт энэ хундагыг Монгол улсын Ерөнхийлөгч Элбэгдорж болон түүний гэргийн эрүүл мэндийн төлөө, Монголын

ард түмний сайн сайхны төлөө, манай хоёр орны найрамдал
нөхөрлөлийн төлөө өргөн тогтооно уу.